

Дундговь аймаг дахь  
Төрийн аудитын газар



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН, ҮР АШИГ”-Т  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ДУА-2022/16-10-ШТА-ГА**

Дундговь дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудитор  
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Х.Наранцацрал  
Утас: 70592225

Цахим хаяг: [dundgovi@audit.gov.mn](mailto:dundgovi@audit.gov.mn)

Ахлах аудитор Д.Ихбаяр Утас: 7059-  
2208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим  
хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-7
	Дүрслэлийн товьёг	7-8
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<b><u>Бүлэг А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх тогтоцоо бүрдээгүй байна.</u></b>	9-12
Аудитын менежер	A.1 Аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.	9-11
Х.Наранцацрал	A.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 604.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	11
Ахлах аудитор	A.3 Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлиггүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 30.6 сая төгрөгийн нэмэлт ажил гүйцэтгүүлсэн байна.	11-12
Д.Ихбаяр		
Аудитор	<b><u>Бүлэг Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт үр дүнтэй байна.</u></b>	12-20
Ч.Оюунтүлхүүр	B.1 Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч төлөвлөгөөгөө баримталж ажиллаагүй байна.	12-14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	B.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 тах чанаргүй, 1 ТАХ дутуу хийгдэж, 4 ТАХ өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон байна.	14-18
ХАЯГ:	B.3 Тайлант онд хэрэгжсэн замын ажилд захиалагчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байна.	18-19
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	B.4 Барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлсэн 1 ТАХ нь хэрэгжилт дутуу хэвээр байна.	19
2022 оны 5 дугаар сар	B.5 Ашиглалтад орсон 40.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.	20
	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22-23
	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	23-24
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	25
	Тайлангийн хавсралтууд	26-40



## Тайлан баталгаажуулах тушаал



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/10

Минсрэг

#### Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүрээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг шийдэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас душиг хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасны тус тус үндэслэн ГУШААХ НЬ:

1. “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (ДУА-2022/16-10-ШТА-ГА) -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага) -ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймагийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах үр дүлгийг талаар 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт харуулахийг Дундговь аймагийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, Орон нутгийн өмчийн газар /Ж.Гантулга/ нарт зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг төгссөн 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гүрээдугаар нэгжийн ихлэх аудитор /Д.Нхбээр/, аудитор /Ч.Оюун-үхүүр/ нарт үүрэг болгосугай.

  
Э.МӨНХТОГТОХ

0012010160

**ТОВЧИЛСОН ҮГС**

<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
<b>БОАЖС</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БСШУС</b>	Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
<b>МХГ</b>	Мэргэжлийн хяналтын газар
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ТАБ</b>	Төрийн аудитын байгууллага
<b>ТАХ</b>	Төсөл, арга хэмжээ
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үндэслэл
<b>УТХО</b>	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа
<b>ХБТХО</b>	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ЭШХО</b>	Эрх шилжсэн хөрөнгө оруулалт

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 9.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

*Аудитын зорилт:*

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөх, тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөр олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх.

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

*Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:*

- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- ✓ Дундговь аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 2021 оны аймаг хөгжүүлэх төлөвлөгөө;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- ✓ Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

*Аудитын хамарсан хүрээ:*

үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;

- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжин ирсэн 4 төсөл арга хэмжээний төлөвлөлт, аймгийн хэмжээнд хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Аудитын явцад Эрдэнэдалай, Өлзийт, Дэлгэрцогт сумдад ажиллаж, барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.

Аудитад улсын төсвөөс 2021 онд санхүүжүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

*Аудитын арга зүй:*

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, аудитын 3-р нэгжийн ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Ч.Оюунтүлхүүр нар

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

2022 оны 3 дугаар сарын 15-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Аудитаар нийт 41.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад төсөвт хохирол учруулсан 1.0 сая төгрөгийг төсөвт нөхөн төлүүлж, 40.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад 1 хугацаатай албан шаардлага, аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ГХБХБГ, ОНӨГ-т нийт 11 заалт бүхий зөвлөмж хүргүүлжээ.

Аудитын дүн

### ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн хэмжээнд 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 48,638.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөв батлагдсан байна.

Үүнээс 4,910.0 сая төгрөгийн 8 ТАХ нь эрх шилжин ирсэн, 43,728.0 сая төгрөгийн 17 ТАХ нь эрх шилжин ирээгүй байна. Эрх шилжин ирсэн ТАХ-ний хувьд 2021 онд 1,330.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Эрх шилжин ирсэн 8 ТАХ-ээс байгаль орчны тохижилт -2, зам гүүр 2, тохижилт, их засварын ажил 4 ажил байна. Сайдын багцаар авч үзвэл тайлант онд хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 50 хувийг БШУС-ын багц, 50 хувийг бусад сайдын багцаас санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд хэрэгжих нийт 8 төсөл, арга хэмжээний 4 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжсэн, 4 нь шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээ бөгөөд үүнээс 1 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжинэ.

### Зургийн товч

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Үнэлгээний хороо байгуулсан хугацаа хэтрэлт	13
Зураг 2	/Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгад хана таазны замаск ховхорсон байдал/	16
Зураг 3	Эрдэнэдалай сумын Цэцэрлэгийн барилгын дээврийн ус зайлуулах хоолой хийгээгүй байдал	16
Зураг 4	“Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга” –ын ажил	38

Зураг 5	“Говь-Угтаал сумын спорт заалны барилга”-ын ажил	38
Зураг 6	“Дундговь аймгийн 800 суудалтай Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга”-ын ажил	39
Зураг 7	“Цагаандэлгэр сумын халуун ус ахуй үйлчилгээний барилга”-ын ажил	39

**График товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1,2	УТХО-аар хийгдсэн хөрөнгө оруулалт салбараар /2017-2021/	10

**Хүснэгтийн товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн бодлогын баримт бичигт УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ нийцсэн байдал	9
Хүснэгт 2	Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн барилгын дээврийн талбайн хэмжээ зөрүү	11
Хүснэгт 3	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн хоног	12
Хүснэгт 4	Хөрөнгийн бүртгэлийн судалгаа	20

**Хавсралтын товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдал	26-28
Хавсралт 2	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Үнэлгээний хорооны хугацаа/ судалгаа	29
Хавсралт 3	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Тендерийн хугацаа / судалгаа	30
Хавсралт 4	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Гэрээ байгуулах хугацаа / судалгаа	31
Хавсралт 5	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Тендерийн үр дүн/ судалгаа	32
Хавсралт 6	Нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний судалгаа / гэрээ сунгасан хугацаагаар/	33-34
Хавсралт 7	“Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын хуучин барилга”-ын чанар төлөв байдлын дүгнэлт №1-1	35
Хавсралт 8	“Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын хуучин барилга”-ын чанар төлөв байдлын дүгнэлт №1-2	36
Хавсралт 9	“Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын хуучин барилга”-ын чанар төлөв байдлын дүгнэлт № 2	37



## БҮЛЭГ А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна.

### А.1 АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ НЭГДСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

2021 онд хэрэгжсэн ТАХ-ний 66.7 хувь нь аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй нийцээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт 48,638.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 24,256.5 сая төгрөгийн 8 ТАХ нь “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл/2021-2025/”, 31,743.0 сая төгрөгийн 10 ТАХ нь “Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөө”, 25,386.3 сая төгрөгийн 7 ТАХ-нь “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” – т тусгагдсан байна.

Харин 22,981.7 сая төгрөгийн 18 ТАХ нь “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, 24,111.5 сая төгрөгийн 17 ТАХ нь “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /2021-2025/”, 16,895.0 сая төгрөгийн 15 ТАХ нь “Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөө”-нд тус тус тусгагдаагүй байна. /Хавсралт 1/

/Хүснэгт 1/

Аймгийн бодлогын баримт бичигт УТХО-ТАХ нийцсэн байдал	Нийцсэн			Нийцээгүй		
	тоо	дүн / сая. төг/	Хувь	тоо	дүн / сая. төг/	Хувь
Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	7	25,386.3	28%	18	22,981.7	72%
2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	8	24,256.5	32%	17	24,111.5	68%
2021 оны хөгжлийн төлөвлөгөө	10	31,743.0	40%	15	16,895.0	60%
<b>Нийт дүн</b>	<b>25</b>	<b>81,385.8</b>		<b>50</b>	<b>63,988.2</b>	

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4<sup>1</sup> -д заасныг зөрчиж байна.

Эдгээр асуудалд өмнөх жилийн аудитад зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд энэ нь аймгийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлогогүй, нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ үр дүнгүй хэрэгжих, хэрэгцээ шаардлагатай асуудалд чиглэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.


<sup>1</sup> / Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2-г заасан төслийн саналыг ирүүлэхдээ дараахь шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна:

- 3.1.4.1. бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;
- 3.1.4.2. Хөгжлийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй нийцэж буй байдал;
- 3.1.4.3. хэрэгцээ шаардлага, үндэслэл;
- 3.1.4.4. мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- 3.1.4.5. төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
- 3.1.4.6. санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл.

Иймд аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /2021-2025/, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх шаардлагатай байна.

Дундговь аймагт 2021 онд УТХО-аар 42 ТАХ-г хэрэгжүүлэх саналыг Сангийн яам болон ТЕЗ нарт хүргүүлсэн боловч эрх шилжүүлсэн 4 ТАХ –г саналд үндэслээгүй баталсан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХО -ын хэлтэст 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 42 ТАХ-г хэрэгжүүлэх санал ирснийг Сангийн яам болон ТЕЗ нарт хүргүүлсэн боловч тайлант онд эрх шилжиж ирсэн 4 ТАХ саналд үндэслэгдээгүй байна. Энэ нь орон нутагт хийгдэх шаардлагатай ТАХ хэрэгжих хугацаа хойшилж хэрэгцээ шаардлагад үндэслэн эрэмбэлсэн ажлын үр дүнг үгүй болгож байна.



Иймээс аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ны санал, түүнд тусгагдсан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон холбогдох нотлох баримтыг үндэслэн төсөвт тусгаж, тусгаадаагүй ТАХ-ны шалтгаан тайлбарыг хүргүүлж байх саналыг УАГ-т уламжлахаар байна.


Аудитын явцад ТАХ-г <https://pimis.publicinvestment.gov.mn/> цахим системээр эрэмбэлсэн материалтай танилцахыг хүсэхэд системийн ажиллагааны алдаатай байдлаас шалтгаалан, холбогдох материалыг үзэх боломжгүй байсан бөгөөд энэ асуудал 2019, 2020 онд тулгарч байсан.

Энэ нь ТАХ-г цахим системд оруулахдаа санал авах, эрэмбэлэх явцыг баримтжуулж авахгүй байгаатай холбоотой байна.

2021 онд эрх шилжин ирсэн ТАХ-ний 50% буюу дийлэнх хувийг БШУС-ын багц эзэлж байгаа бөгөөд хөрөнгө оруулалт хийгдсэн салбарын сүүлийн 5 жил /2017-2021 он/-ийн судалгаагаар нийт санхүүжилтийн дийлэнх буюу 26.8-56.1 хувийг боловсролын салбарт, 15.7-48.9 хувийг дэд бүтцийн салбарт, 19.5-32.5 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж, хамгийн бага буюу 0.3-12.6 хувийг соёл, спорт, хөдөө аж ахуй болон бусад салбарт зарцуулсан байна. /График:1,2/

/График:1/

/График:2/



Иймд хөрөнгө оруулалт бага хийгдэж байгаа салбарын хэрэгцээг судалж аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх шаардлагатай байна.



### **А.2 ЗУРАГ ТӨСӨВ, ТООЦОО СУДАЛГАА ХИЙГДЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

2021 онд УТХО-аар эрх шилжин хэрэгжүүлсэн 4 ТАХ-ээс 3 ТАХ –г зураг төсөвгүй баталсан байна.

Хүснэгт 2

УТХО-аар 2021 онд шинээр хэрэгжсэн Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилгын их засвар болон “Дундговь аймгийн Дэл уул, Цагаан суваргын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах” ажлын зураг төсөл нь 2021 онд буюу төсөв батлагдсанаас хойш, батлагдсан төсвийн дүнд нь тохируулан шинээр боловсруулсан байна. Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилгад хийгдсэн дээврийн засварын ажлын зураг төсөл, төсвийг харьцуулахад Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын дээврийн талбайн хэмжээ Дэлгэрцогт сумын Цэцэрлэгээс 241 мкв-аар илүү боловч төсөв нь 3.1 сая төгрөгөөр бага төсөвлөсөн байна. /Хүснэгт 2/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөл хийгдсэн он	Дээвэр хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/
1	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар / Эрдэнэдалай сум /	2021	432 мкв	40.0
2	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дэлгэрцогт сум/	2021.02 сар	191 мкв	43.1

Энэ нь УТХО-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдахад орон нутгийн оролцоо бага, батлагдсан санхүүжилтдээ тааруулж зураг төсөв боловсруулдаг, зураг төслийг анх боловсруулахдаа хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, объект дээр бодит хэмжилт хийгээгүй, зураг төсөл боловсруулах норм дүрэм баримтлаагүйгэй холбоотой байна.

Иймээс улсын төсөв хэмнэгдэх боломж хязгаарлагдаж үр дүнгүй, гүйцэтгэгч байгууллагад илүү төсөв олгож, төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах үр дагавар бий болсон байна. Тус асуудал нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>2</sup>-д заасныг зөрчсөн байна.

ТЭЗҮ, тооцоо судалгаа нь бодитой хийгдсэн, зураг төслийн шаардлага хангасан зураг төсөлтэй ТАХ-г төсөвт тусгаж байх талаарх зөвлөмжийг ТЕЗ нарт хүргүүлэхээр УАГ-т уламжлахаар шийдвэрлэлээ.

### **А.3 ЗАРИМ ТАХ-НИЙ ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХДАА ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТӨСӨВТ ӨРТГИЙГ ТУСГААГҮЙГЭЭС 30.6 СЯА ТӨГРӨГИЙН НЭМЭЛТ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЖЭЭ.**

2021 он шинээр хэрэгжүүлсэн 2 барилгын засварын ажлын зураг төсөвт ороогүй зайлшгүй хийх шаардлагатай 30.6 сая төгрөгийн нэмэлт ажил хийгдсэн байна. Үүнд;

1. “Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн барилгын засвар”-ын ажлын зураг төсөвт ороогүй 8.3 сая төгрөгийн нэмэлт ажлыг гүйцэтгэгч байгууллага өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн байна.

<sup>2</sup> /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./

2. “Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын их засвар”- ажлын зураг төсөвт тусгаагүй 22.3 сая төгрөгийн нэмэлт ажлыг зураг төсөвт тусгагдсан боловч захиалагчийн хүсэлтээр “холбоо дохиолол камержуулах”, “сүүдрэвч барих” ажлын төсвийг шилжүүлэн гүйцэтгэсэн байна.

Эдгээр асуудал нь зураг төслийг боловсруулахдаа бодит хэмжилт, тооцоо судалгааг хангалттай хийдэггүй, ашиглагч байгууллага өөрсдөө хариуцан зураг төслөө хийлгэдэг боловч хийгдэх ажлын талаар саналаа бүрэн тусгуулдаггүй, техникийн нөхцөл олгож буй мэргэжлийн байгууллагуудын албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

*Иймд мэргэжлийн байгууллагуудад зураг төсөл боловсруулахдаа объект дээр бодит хэмжилт хийн, ашиглагч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа хийж байх, техникийн нөхцөл олгохдоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллах шаардлагатай байна.*

**ТАХ-ны барилгын ажлын гүйцэтгэх хугацааг ажлын цар хүрээ, онцлог шинж чанарт үндэслэн оновчтой тодорхойлоогүй байна.**

*Хүснэгт 3 / ТАХ-г гүйцэтгэсэн хоног/*

Д/д	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Ажил гүйцэтгэх хоног
1	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар /Эрдэнэдалай сум /	40.0	51
2	Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн засвар /Дэлгэрцогт сум/	80.0	19
3	Цэцэрлэгийн барилгын их засвар / Өлзийт сум/	400.0	450
4	Сургуулийн барилгын их засвар / Өлзийт сум/	300.0	448

“Дэлгэрцогт сумын барилгын засвар”-ын ажлыг 19 хоногт гүйцэтгүүлсэн байхад “Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засвар”-ын ажлыг 51 хоног буюу 32 хоногийн илүү хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Энэ нь ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа ажлын цар хүрээ, нөхцөл байдал дүн шинжилгээ хийгээгүй, мөн тендер шалгаруулалтад хугацаа алдаж гэрээг оройтож

байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

*Иймд ажил гүйцэтгэх гэрээний хугацааг тооцохдоо тухайн ажлын цар хүрээ, хүндрэл бэрхшээл, төвөгтэй байдал зэргийг тооцон төлөвлөх шаардлагатай байна.*

## **БҮЛЭГ Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт үр дүнтэй байна.**

### **Б.1 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БОЛОВЧ ХАА-НИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАРИМТАЛЖ АЖИЛЛААГУЙ БАЙНА.**



**ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн боловч зарим ТАХ-ний тендер шалгаруулалт зохион байгуулахдаа хугацаа алдсан байна.**

Дундговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4,860.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжин ирсэн байна.


Үүнээс 4,650.0 сая төгрөгийн 4 ТАХ нь өмнөх онд, 210.0 сая төгрөгийн 4 ТАХ нь 2021 оны эхний улиралд буюу хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

ТАХ-ны хэрэгжих хугацааны хувьд тайланд онд хэрэгжих 7 ТАХ, он дамжин хэрэгжих 1 ТАХ байна. 2021 онд шинээр эрх шилжин ирсэн нийт 4 ТАХ-ний хувьд эрх шилжин ирсэн хугацаанаас хойш 26-аас дээш хоногийн дараа үнэлгээний хороо байгуулж хугацаа алдсан байна.

Зураг 1

#### ХАА-нд мөрдсөн хугацааны талаар:

Үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн хугацаа болон байгуулсан хугацааг харьцуулан үзэхэд 26-35 хоногийн хэтрэлттэй 2 ТАХ, төлөвлөгөөнөөс 36-60 хоног хэтрүүлсэн 1 ТАХ, 61-80 хоногийн хэтрэлттэй 1 ТАХ байна.



Дундговь аймгийн Дэл уул, Цагаан суварга орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлыг 2021.03.19-ний өдөр үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн боловч 2021.06.03-ны өдөр үнэлгээний хороо байгуулж нийт 76 хоног, Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар /Эрдэнэдалай сум/ ТАХ нь 2021.02.25-ны өдөр үнэлгээний хороо байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч 2021.04.23-ны өдөр үнэлгээний хороо байгуулагдаж нийт 57 хоногийн хугацааны хэтрэлттэй байна. /Хавсралт 2/

Тендер зарлахаар төлөвлөсөн хугацаанаас 50 хоногийн дараа Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажил, 95 хоногийн дараа Дундговь аймгийн Дэл уул, цагаан суваргын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах ажлын тендерийг зарласан, 27-40 хоногийн дараа тендер зарласан үлдсэн 2 ТАХ байна. /Хавсралт 3/

Бүх ТАХ-ний тендер хүлээж авах эцсийн хугацаа нь хуульд<sup>3</sup> заасан шаардлагын дагуу хугацаандаа тендерийн баримт бичиг хүлээн авсан байна. Мөн тендер зарцуулсан нийт хугацаа нь тендерийн хүчинтэй хугацаанд үнэлгээний хорооны дүгнэлт гарсан байна.



Гэрээ байгуулах эрх олгох хугацаа болон төлөвлөсөн хугацаатай харьцуулан судлахад төлөвлөснөөс 30-40 хоногийн хугацаа хэтрэлттэй 2 ТАХ, 75-104 хоногийн хугацаа хэтрэлттэй Дундговь аймгийн Дэл уул, Цагаан суварга орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах ажлын ТАХ байна. /Хавсралт 4/ Төлөвлөсөн хугацаанаас 9-19 хоногийн дараа тендер шалгарсан компанитай гэрээ байгуулсан байна.

Энэ нь ХАА зохион байгуулах хугацааг төлөвлөхдөө тухайн ТАХ-ны цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэлгүй бүх ТАХ-г ижил цаг хугацаанд төлөвлөсөнтэй холбоотой байна.

Иймд ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ний цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж байх, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулж байх шаардлагатай байна.

<sup>3</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24.3 Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.



Тайлант онд нийт 4 ТАХ-ний ХАА-нд харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж 4 тендер амжилттай болж 2 тендер буюу “Дундговь аймгийн Дэл уул, Цагаан суварга орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах”, “Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах” ажлуудыг 2 удаа тендер шалгаруулалт зохион байгуулж, тендер амжилттай болсон. /Хавсралт 5/

Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, шилэн дансны <https://shilendans.gov.mn/> цахим системд мэдээлсэн байна.

## **Б.2 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН 1 ТАХ ЧАНАРГҮЙ, 1 ТАХ ДУТУУ ХИЙГДЭЖ, 4 ТАХ ӨМНӨХ ОНУУДААС ХЭРЭГЖИЖ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАЙНА.**

*Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.*

Эрх шилжин ирсэн 8 ТАХ-ээс 7 ТАХ нь гэрээний хугацаандаа хэрэгжиж, 1 ТАХ хугацаандаа хэрэгжээгүй байна. Хугацаандаа хэрэгжсэн 7 ТАХ-ний 3 ТАХ нь нэмэлт гэрээ байгуулан хугацааг сунгасан байна. /Хавсралт 6/



### **Нэмэлт гэрээ байгуулан хугацаа сунгасан ТАХ:**

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам- Сайнцагаан сум 2,8 км”, “Сургуулийн барилгын их засвар-Өлзийт сум” зэрэг ТАХ Ковид -19 цар тахал гарсантай холбогдуулан компанийн хүсэлтээр гэрээний хугацааг сунгасан байна.

“Сумын төвийн хатуу хучилттай авто зам 2км –Эрдэнэдалай сум” /багц -2/ – ажлын гүйцэтгэгч “Анарзоне” ХХК нь авто зам дагуу байрлуулах гэрэлтүүлгийн ажлыг 2020 онд бүрэн дуусгаж, авто замын ажилтай цуг хүлээн авах байсан боловч багц-1 авто замын ажил удааширсантай холбоотойгоор гэрээний хугацааг сунгасан байна.

Гэрээний хугацаа сунгахад COVID-19 цар тахлын нөхцөл нөлөөлсөн боловч гүйцэтгэгч байгууллагын хариуцлагагүй байдлаас шалтгаалсан асуудал байна.

### **Гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ:**



“Сумын төвийн хатуу хучилттай авто зам-2.8 км –Эрдэнэдалай сум” /багц – 1/ авто замын ажлын гүйцэтгэгч “Өлзий Хутгийн Наран” ХХК-тай 1,505.4 сая төгрөгийн төсөвтэй байгуулсан гэрээний хугацаа 2020 оны 10 сард дууссан боловч гэрээний хугацаанд ажлаа бүрэн хийгээгүй, гүйцэтгэгч байгууллага 2021 онд гэрээний хугацааг сунгуулах хүсэлт өгсөн боловч гэрээг сунгаагүй, гэрээнд заасан алданги тооцоогүй байна. Гэрээ сунгаагүй шалтгаан нь тухай үед сонгуулийн үр дүнгээр Засаг дарга солигдож ГХБХБГ-ын хяналтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулах шаардлага тавьж биелэлтийг одоо болтол хэрэгжүүлээгүй хэвээр байгаатай холбоотой байна.

Эдгээр асуудал нь ХАА зохион байгуулах, гэрээ байгуулах зэрэгт хугацаа алдсан, захиалагч гэрээний хугацааг бодитой зөв тооцоолоогүй, COVID-19 цар тахал болон гүйцэтгэгч байгууллагын хариуцлагагүй байдал, 2 байгууллагын үл ойлголцол зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.14<sup>4</sup>, 6.1.7<sup>5</sup> дахь заалт, “Сумын төвийн хатуу хучилттай автозам-2км /Эрдэнэдалай/” ажлын №ЗТХЯ/201901046/02/01 дугаартай гэрээний 12<sup>6</sup> дах заалтыг зөрчсөн байна.

*Иймд хөрөнгө оруулалтын ажлын үе шатны хуваарийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, гэрээний хугацаанд ажил бүрэн хийгдэхгүй байгаа нөхцөл шалтгааныг цаг алдалгүй тодруулж хариу арга хэмжээ авах асуудал дээр гүйцэтгэгч байгууллагатай хамтран шийдвэр гаргаж гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах талаарх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.*

#### **Чанаргүй гүйцэтгэсэн барилгын ажил:**

**“Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын их засвар”-ын 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил:**

Засварын ажлын гүйцэтгэгч “Оддатайж” ХХК нь гэрээг анх 2020 оны 05 сард байгуулж, 2021 оны 8 сард хүлээлгэн өгөх байсан боловч 2020 оны 12 сард буюу хугацаанаас өмнө хүлээлгэн өгсөн боловч хүлээн авснаас хойш ашиглалтын явцад нэлээдгүй эвдрэл гэмтэл гарсан байна.

1. Хүүхдийн бие засах өрөөнүүдэд ус алдаж, доошоо нэвчилт үүссэн, тендерт оролцохдоо мэргэжлийн ажилчдыг ажиллуулахаар жагсаалтыг ирүүлсэн боловч тус цэцэрлэгийн ажилтнуудаар хаалга суулгах, замаск татуулах зэрэг ажлыг хийлгүүлснээр хана таазны замаск ховхорсон, хаалгануудыг муу суулгасан, усанд ордог өрөө, эрхлэгчийн өрөөнд шинээр бие засах өрөө нэмэлт ажлаар хийгдсэн нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна. /Зураг 2/

2. Гал тогооны цахилгаан монтажны ажил чанаргүй хийгдсэний улмаас ажилтны эрүүл мэндэд хохирол учирсан байна.

Иймээс гүйцэтгэгч байгууллагаар /“Одда тайж ХХК”/ чанаргүй хийгдсэн дараах ажлуудыг дахин гүйцэтгүүлж авсан байна. Үүнд:

- 3 цонхны хагарсан шилийг солих;
- Гал тогооны өрөөний цахилгаан монтаж, 380 квт-ын цахилгааны шийтийн байрлалыг солих;
- Ил байрлуулсан цахилгааны утсыг далдалж оролтуудыг өөрчлөх;
- Урлаг зааланд 2 ширхэг суултуур суулгах;
- Багш нарын амралт, цайны өрөөг засварлах ;

Мөн 2021 онд цэцэрлэгийн барилгын нийт талбайн цахилгааны монтаж, газардуулга шинэчлэх шаардлага гарч тус ажилд байгууллагын төсвөөс 1.4 сая төгрөг зарцуулсан байна.

<sup>4</sup> Төслийн гүйцэтгэгч этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулж, гэрээ байгуулах бөгөөд гэрээтэй холбоотой аливаа зохицуулалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

<sup>5</sup> Гэрээний талууд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

<sup>6</sup> Замын ажлыг нэг маягийн зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээнснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

*Зураг 2 /Өлзийт сумын цэцэрлэгийн барилгад хана таазны замаск ховхорсон байдал/*



Энэ нь захиалагч байгууллагын хяналт хангалтгүй хийгдсэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангуулж барилгын засварын ажлыг хүлээж аваагүй зэргээс шалтгаалж зарим ажил чанаргүй хийгдэж төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдсан байна.

*Иймээс захиалагч болон захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага дээрх илэрсэн зөрчилд дүгнэлт хийж, барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл чанарт байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, зураг төсөв, норм нормативд нийцээгүй чанаргүй хийгдсэн ажлыг хүлээж авахгүй, ашиглалтад оруулахгүй, санхүүжилт олгохгүй байх шаардлагатай байна.*

*Дутуу гүйцэтгэсэн барилгын ажил:*

***“Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засвар”-ын 40.0 сая төгрөгийн төсөвтэй ажил;***

Засварын ажлын гүйцэтгэгч “ЮуБиЖи” ХХК магадалшгүй ажлын зардал болох 0.7 сая төгрөгөөр ус зайлуулах хоолой хийсэн акт үйлдэж санхүүжилт авсан боловч ажлын бодит гүйцэтгэлээр ус зайлуулах хоолойг хийлгүй ашиглагч байгууллагын даргатай өөрсдөөр нь хийлгэхээр тохиролцож хувийн дансанд нь 1.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тус ажил огт хийгдээгүй байлаа. /Зураг 3/ Энэ нь захиалагчийн хяналт муу хийгдсэнээс шалтгаалж ажил дутуу хийгдэж, улмаар санхүүжилт үрэгдэх нөхцөл байдал үүссэн байна.

*Зураг 3 /Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын дээврийн ус зайлуулах хоолой хийгээгүй байдал/*



Тус зөрчил нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.17<sup>7</sup>-д, Төсвийн тухай хуулийн 6.4.1<sup>8</sup>-т заасныг тус тус зөрчсөн.

*Иймээс аудитын явцад 1.0 сая төгрөгийг аймгийн Ду.БШУСайдын ЭШХО-лалтын дансанд төлүүлж, гүйцэтгэгч байгууллагаар барилгын дээврийн ус зайлуулах хоолой шинээр авч суурилуулах ажлыг гүйцэтгүүлэн, хүлээн авч бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг нь олгох талаарх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.*

**Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 4 барилга байгууламж байна.**

**COVID-19 цар тахал, бараа материалын үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан 2021 онд ажил хийгдээгүй барилгууд;**

1. “Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга” –ын ажил 1,228.3 сая төгрөгийн төсөвтэй ажил 50 хувийн гүйцэтгэлтэй ба гүйцэтгэгч “Хэрмээдэй” ХХК нь COVID-19 цар тахал, бараа материалын үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан 2021 онд ажил хийгээгүй гэсэн тайлбарыг өгч, гэрээ сунгахаар хүсэлт ирүүлсэн байна. 2021 онд ЗГ-ын 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу 2021 онд төсөвт тусгагдсан үлдэгдэл 573.3 сая төгрөгийн төсвийг ТЕЗ-ын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан бөгөөд 2022 онд гэрээг сунгасан тохиолдолд ажлыг үргэлжлүүлэн хийх боломжтой байна. */Зураг 4 Тайлангийн хавсралтуудын арын хэсэгт/*

2. “Говь-Угтаал сумын спорт заалны барилга”-ын ажил 853.2 сая төгрөгийн төсөвтэй 29 хувийн гүйцэтгэлтэй ба ажлыг гүйцэтгэгч “Бум констракшн” ХХК нь 2019, 2020 онд олон ажил зэрэг гүйцэтгэсэн шалтгаанаар ажил нь хийгдээгүй 2020 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг дээд шатны төсөвт татуулж 2021 онд улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй байна. Харин 2022 онд улсын төсөвт 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гэрээ сунгах хүсэлт ирүүлсэн бөгөөд ажил үргэлжлүүлэн хийгдэх боломжтой байна. */Зураг 5 Тайлангийн хавсралтуудын арын хэсэгт/*

**Дуусаагүй орхигдсон барилга:**

**“Дундговь аймгийн 800 суудалтай Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга”-ын ажил**

БСШУС-ын багцаас 10,543.7 сая төгрөгийн төсөвтэй, гүйцэтгэгч “Суурь ХХК”-тай 6,800.0 сая төгрөгөөр, 2012-2014 онд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

2012 онд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2,040.0 сая төгрөг авсан, бодит хийгдсэн ажил 680.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Барилга угсралтын ажил 2012 онд эхэлж барилгын суурийн ажил болон баганын арматурчлалын ажил хийгдэн зогсож, 2019 онд газар шороо, цутгамал төмөр бетон бүтээцийн угсралтын ажил хийгдэж түүнээс хойш ажил хийгдээгүй байна. */Зураг 6 Тайлангийн хавсралтуудын арын хэсэгт/*

Барилгын баганаан суурийн бетон үйрч бутарсан, баганын арматурчлал зэвэрсэн ажлууд дээр 2015.05.01-ний өдөр “Реконстракшн” төвөөр дүгнэлт гаргуулж, захиалагч БСШУСЯ, Барилгын хөгжлийн төвтэй хамтран барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шийдвэр гарган, албан тоотоор гүйцэтгэгч компанид хүргүүлсэн боловч одоог хүртэл барилга угсралтын ажил эхлээгүй байна. Захиалагч байгууллагаас гэрээ дүгнэж, гэрээг цуцлах хүсэлтийг 2014, 2016, 2017, 2018 онд албан бичгээр удаа дараа БСШУСЯ-ны сайдад хүргүүлсэн боловч хариу арга хэмжээ аваагүй байна. Мөн энэ ажил Соёлын яамны сайдын багцад хамааралтай болсон.

<sup>7</sup> 4.1.17.Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно

<sup>8</sup>төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

2014-2018, 2020, 2021 онд улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй, 2019 онд 2,000.0 сая төгрөг, 2022 онд 1,000.0 төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Тус барилгын ажлын тендер шалгаруулалт, гэрээ байгуулах ажил нь анх БСШУ-ны яаман дээр зохион байгуулагдсан тул орон нутагт ажлын гүйцэтгэл, санхүүжилт, хэрэгжихгүй удааширалтай байгаа шалтгаан, түүний шийдвэрлэлтийн явцыг мэдэхэд төвөгтэй, албан ёсны мэдээлэл бага байгаа бөгөөд хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулахад хүндрэлтэй байна. */Эх сурвалж; Аймгийн ЗДТГ-ын ХБТХО -ын хэлтсээс ирүүлсэн мэдээлэл/*

Аудитын явцад тус барилгын хэрэгцээ шаардлагыг судалж үзэхэд одоогийн театрын барилга нь 1984 онд “Кино театр”-ын зориулалтаар баригдан ашиглалтад орж байсан бөгөөд 2015 онд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тус барилга нь **“Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрх зөрчигдөж, соёлын үйл ажиллагааг хэвийн явуулах боломгүй байна”** гэж дүгнэгдсэн байна. */Хавсралт7-9/*

Тус дүгнэлтээр тодорхой бус шалтгаанаар дуусаагүй орхигдсон дээрх барилга нь манай аймгийн хувьд нэн тэргүүний шаардлагатай байгаа нь нотлогдож байгаа тул барилгын ажил удааширч байгаа учир шалтгааныг тогтоож асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажлыг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар Соёлын яаманд зөвлөмж хүргүүлэх саналыг ҮАГ-т уламжлахаар шийдвэрлэлээ.

#### ***“Цагаандэлгэр сумын халуун ус ахуй үйлчилгээний барилга”-ын ажил;***

Барилга хот байгуулалтын яамны сайдын багцаас 250.0 сая төгрөгийн төсөвтэй, гүйцэтгэгч “Одда тайж ХХК”-тай 237.3 сая төгрөгөөр 2018 оны 10 сарын 18-ны өдрөөс 12 сарын 18-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэх байсан боловч 2021 оны байдлаар 2-р давхрын гадна хана, хамар ханын өрлөгийн ажил хийгдээд ажил зогссон. Тус ажлын бодит гүйцэтгэл 76% бөгөөд гүйцэтгэлээр нь 178.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Гүйцэтгэгч “Одда тайж” ХХК нь тус онд олон ажил давхар гүйцэтгэсэн мөн захиалагч болон ашиглагч байгууллагын ажлын хариуцлага, хөөцөлдлөгөө муугаас шалтгаалж 2018 оноос хойш ажил хийгдээгүй, улсын төсөвт санхүүжилт тусгагдаагүй байна. */Зураг 7 Тайлангийн хавсралтуудын арын хэсэгт/*

*Иймээс барилгын ажлын явц удааширалтай байгаа учир шалтгааныг тогтоож, санхүүжилтийг төсөвт тусгуулах, барилгын ажлыг эхлүүлэх ажлыг ашиглагч байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулж тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.*



#### **Б.3 ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖСЭН ЗАМЫН АЖИЛД ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТААР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

1. “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто зам-2.0 км” ажлын багц-1 гүйцэтгэгч “Өлзий Хутгийн Наран” ХХК-д ГХБХБГ-аас ажлыг зураг төслийн дагуу хийгээгүй, авто замын далангийн газар шороо, суурийн ажил зураг төслийн тоо хэмжээнээс дутуу хийгдсэн, геодезийн хэмжилт хийгдээгүй, ногоон байгууламжийн зурвас, явган хүний замын далан, хөвөөний ажил бүрэн хийгдээгүй, замын бетон хучлагын гадаргууд их хэмжээний хагарал үүссэн, гадаргуугийн тэгш байдал хүлцэх алдаа, мөн агшилтын заадас, гулсалтаас хамгаалсан гадаргуугийн барзгаржилт гаргаагүй зэрэг зөрчлийг арилгаж, замын ажлыг эхлүүлэх тухай албан бичгээр хандсан боловч одоо болтол үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй байна.

Харин 2022 оны 4 сард Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн болон аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ГХБХБГ, сумын ЗДТГ,

гүйцэтгэгч компанийн менежер, зургийн компанийн менежерийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг авто замын нөхцөл байдалтай танилцаж, 2019 ба 2020 онд хийсэн газар шорооны ажил, өндөржилт, 2 ус зайлуулах хоолой, авто замын хашлага, өндөржилтөөс хамааран гэрэлтүүлгийн засвар хийх ажлын үе шатны хуваарь гарган батлуулан 2022 оны 06 сарын 01-ний өдрийн дотор хийж гүйцэтгэсэн тохиолдолд гэрээг дахин сунгахаар харилцан тохиролцож, өмнө нь гүйцэтгэсэн ажлыг засварлах ажлын үе шатны хуваарийг гаргасан байна. Иймээс тус ажил хийгдэж эхлэх суурь нь тавигдсан байна.

“Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын их засвар”-ын ажлын явцад ашиглагч байгууллагын хүсэлтээр их засварын ажлын төсөвт тусгагдсан 10.5 сая төгрөгийн холбоо дохиоллын ажил, 6.2 сая төгрөгийн сүүдрэвч барих ажлын төсвийг шилжүүлж барилгын засварын ажлын төсөвт тусгагдаагүй 22.3 сая төгрөгийн ажлыг нэмэлт ажлыг гүйцэтгэсэн боловч сүүдрэвч барих ажлын төсвийг шилжүүлж нэмэлт ажилд зарцуулах талаарх тохиролцоо хийсэн нотлох баримт байхгүй байна. Засварын ажлын зураг төсөвт зохиогчийн хяналт болон ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хангалтгүй хийгдсэнтэй холбоотой байна.

Эдгээр асуудлууд нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах тайлагнах журам” 5.2.2<sup>9</sup>д, “Барилгын тухай” хуулийн 14.1<sup>10</sup>, 14.1.1<sup>11</sup>, 14.1.2<sup>12</sup>, 14.1.3<sup>13</sup>, 14.6<sup>14</sup> дах заалтыг тус тус зөрчиж байна.

*Иймд зураг, төсөвт тусгагдсан ажлын санхүүжилтийг шилжүүлж нэмэлт /зураг төсөвт тусгагдаагүй/ ажил хийсэн тохиолдолд холбогдох хууль журмын дагуу баримтжуулж, зураг төсвийн гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлтэй тулган баталгаажуулалт хийж, хөрөнгө оруулалтын норм норматив чанар байдалд хяналт хийж байгаа байгууллага, албан тушаалтны ажлын хариуцлагыг өндөржүүлж ажиллах талаар Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.*

#### **Б.4. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДАНСНААС САНХҮҮЖҮҮЛСЭН 1 ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ ДУТУУ ХЭВЭЭР БАЙНА.**

“Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ын ажил өмнөх онд 655.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэж санхүүжилт авах байсан боловч ажлын гүйцэтгэл дутуу учир 486.7 сая төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 186.3сая төгрөг, тайлант онд 181.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 573.7 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын зохиогчийн хяналт хийгдээгүй тул 0.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

<sup>9</sup> Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналтыг тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл чанарт байнгын шууд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.

<sup>10</sup> Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна:

<sup>11</sup> зураг төслийн дагуу баригдсан байх;

<sup>12</sup> барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

<sup>13</sup> Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

<sup>14</sup> Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.



**Б.5 АШИГЛАЛТАД ОРСОН 40.0 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛ, ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА.**

/Хүснэгт 4/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Бүртгэлд тусгах дүн	Бүртгэлд тусгасан дүн
1	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дундговь, Дэлгэрцогт/	65.9	65.9
2	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар/Дундговь, Эрдэнэдалай сум/	38.5	38.5
3	Сургуулийн барилгын их засвар/Дундговь Өлзийт сум/	377.5	377.5
4	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь Өлзийт сум/	278.9	278.9
5	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	40.0	0.0
6	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/	2,176.0	2,176.0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2,976.8</b>	<b>2,936.8</b>

Тайлант онд 2,936.8 сая төгрөгийн санхүүжилттэй 5 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгасан боловч Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлын хүрээнд бий болсон 40.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Тайлант онд хэрэгжиж дууссан барилгын 4 ажлыг барилга байгууламжийн хувийн хэрэгт хөтөлсөн байна.

Хөрөнгийг бүртгэл, тайлан тусгаагүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>15</sup>, 14.4.2<sup>16</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

*Иймээс Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлын хүрээнд бий болсон 40.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байсан зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.*

**Өмнөх аудитаар өгөгдсөн 1.5 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй байна.**

Өмнөх оны аудитаар аймгийн Засаг даргад 412.3 сая төгрөгийн 6 албан шаардлага, 4 зөвлөмж, Орон нутгийн өмчийн газарт 3 зөвлөмж хүргүүлснээс 410.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 7 зөвлөмж хэрэгжсэн байна.

Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч компани “Эйч Ар Ви Констракшн” ХХК нь тусгаарлах хана, салхивч, гадна бохир, хаалганд их засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн боловч барилгын ажлын явцад суурилуулсан ус халаагчийг ажилд оруулан, хэвийн ажиллагааг хангуулах ажлыг хийж гүйцэтгээгүй, ГХБХБГ-аас хяналт хийгдээгүй, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Аймгийн төвд хийгдсэн 2.8 километр хатуу хучилттай авто зам ашиглалтад орж аймгийн төвийн хатуу хучилттай замын урт 16.8 километр болсон байна.**

2019-2021 онд УТХО-аар 2,176.0 сая төгрөгийн өртөгтэй “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ын хүрээнд аймгийн төвийн гэр хороололд 2.8 километр хатуу хучилттай зам ашиглалтад орж аймгийн төвийн хатуу хучилттай замын урт 16.8 километр болсон байна. Тус зам ашиглалтад орсноор гэр хорооллын орчинд тоосжилт багасаж аймгийн төвийн өнгө үзэмж сайжирч, иргэд замаар тав тухай зорчих боломж бүрдсэн байна.

<sup>15</sup> Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

<sup>16</sup> бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;



## Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

### **УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ҮР ДҮН МУУТАЙ БАЙНА.**

**Бүлэг А. 2021 онд эрх шилжин ирж хийгдсэн 4 ТАХ-нь хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор эрэмбэлэгдээгүй, зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй, 3 ТАХ-нь дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт ороогүй байна.**

*А.1 Аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.*

*А.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.*

*А.3 Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлиггүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 30.6 сая төгрөгийн нэмэлт ажил гүйцэтгүүлсэн.*

**Бүлэг Б. ТАХ-ний худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагдсан боловч захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс 1 ТАХ чанаргүй, 1 ТАХ дутуу хийгдэж, 4 ТАХ өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон байна.**

*Б.1 Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баримталж ажиллаагүй байна.*

*Б.2 Захиалагч ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс 1 ТАХ чанаргүй, 1 ТАХ дутуу хийгдэж, 4 ТАХ өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон байна.*

*Б.3 Тайлант онд хэрэгжсэн замын ажилд захиалагчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна.*

*Б.4 Барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлсэн 1 ТАХ –ний хэрэгжилт дутуу хэвээр байна.*

*Б.5 Ашиглалтад орсон 40.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.*



## Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

### **Аймгийн Засаг даргад:**

1. Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх;
2. Хөрөнгө оруулалт бага хийгдэж байгаа салбарын хэрэгцээ шаардлагыг судалж аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх;
3. Мэргэжлийн байгууллагуудад зураг төсөл боловсруулахдаа объект дээр бодит хэмжилт хийн, ашиглагч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа хийж байх, техникийн нөхцөл олгохдоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллах;
4. Эрдэнэдалай сумын Цэцэрлэгийн барилгын дээврийн ус зайлуулах хоолой шинээр авч суурилуулах ажлыг гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлэн, хүлээн авч бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгох;
5. Хөрөнгө оруулалтын ажлын үе шатны ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, гэрээний хугацаанд ажил бүрэн хийгдэхгүй, өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон ажлуудын нөхцөл шалтгааныг тодруулж, хариу арга хэмжээ авч гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах;
6. Зураг, төсөвт тусгагдсан ажлын санхүүжилтийг шилжүүлж нэмэлт /зураг төсөвт тусгаадаагүй/ ажил хийсэн тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу баримтжуулж, зураг төслийн дагуу гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлтэй тулган баталгаажуулалт хийж, хөрөнгө оруулалтын норм норматив, чанар байдалд тавих хяналтыг сайжруулах;

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад:**

1. Ажил гүйцэтгэх гэрээний хугацааг тооцохдоо тухайн ажлын цар хүрээ, хүндрэл бэрхшээл, төвөгтэй байдал зэргийг тооцон гэрээнд тусгах;
2. Захиалагчийг төлөөлж хяналтыг тавьж байгаа байгууллагуудын барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт хяналт хийж байгаа байдал, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан хүлээн авч ашиглалтад оруулж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага хангаагүй чанаргүй хийгдсэн ажилд санхүүжилт олгохгүй байх;

### **Орон нутгийн өмчийн газарт:**

1. ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ний цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулж байх;

### **Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:**

1. Эрдэнэдалай сумын Цэцэрлэгийн барилгын дээврийн ус зайлуулах хоолой шинээр авч суурилуулах ажлыг гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлэн, хяналт хийж хүлээн авах;

2. Барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлд хийх захиалагчийн хяналтыг сайжруулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, зураг төсөв, норм нормативд нийцээгүй, чанаргүй хийгдсэн ажлыг хүлээж авахгүй байх.



## Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

ҮАГ-аар дамжуулан Сангийн яам болон бусад яамдын ТЕЗ нарт дараах зөвлөмжийг хүргүүлэх саналыг уламжилж байна. Үүнд:

### Үндэслэл 1:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХО -ын хэлтэст 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 42 ТАХ-г хэрэгжүүлэх санал ирснийг Сангийн яам болон ТЕЗ нарт хүргүүлсэн боловч тайлант онд эрх шилжиж ирсэн 4 ТАХ тус саналд үндэслэгдээгүй байна. Энэ нь орон нутагт хийгдэх шаардлагатай ТАХ-ний хэрэгжих хугацаа хойшилж, хэрэгцээ шаардлагад үндэслэн эрэмбэлсэн ажлын үр дүнг үгүй болгож байна. /Бүлэг А.1-ээс дэлгэрэнгүй харна уу/

### Санал 1:

Иймд аймгийн ТЕЗ-аас Сангийн яам болон бусад яамдын ТЕЗ нарт хүргүүлсэн УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ны санал, түүнд тусгагдсан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон холбогдох нотлох баримтыг үндэслэн төсөвт тусгаж, тусгаагагүй ТАХ-ны шалтгаан тайлбарыг хүргүүлж байх;

### Үндэслэл 2:

УТХО-ын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар зураг төсөл, тооцоо судалгаа хийгдээгүй ТАХ-г төсөвт тусгаж баталсантай холбоотой зөрчил давтан гарсаар байна.

Тухайлбал 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Зураг төсөл нь төсөв батлагдсанаас хойш хийгдсэн, бодит хэмжилт, хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаанд үндэслэн хийгдээгүй;
- Зайлшгүй хийх шаардлагатай ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулснаас 30.6 сая төгрөгийн нэмэлт ажлыг төсөвт тусгагдсан өөр ажлын төсвийг шилжүүлж хийсэн;
- Батлагдсан ТАХ-ний байршлыг өөрчилсөн, зураг төсөлд тусгасан ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн. /Бүлэг А.2, А.3-аас дэлгэрэнгүй харна уу/

### Санал 2:

ТЕЗ нарт “ТЭЗҮ, зураг төсөл, тооцоо судалгаа хийгдсэн ТАХ-г төсөвт тусгаж байх, зураг, төслийг бодит хэмжилт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, зураг, төслийг боловсруулж байгаа гүйцэтгэгч компаниудын ажлын хариуцлагыг өндөржүүлэх талаар зөвлөмж хүргүүлэх”

### Үндэслэл 3:

“Дундговь аймгийн 800 суудалтай Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга”-ын ажил

БСШУС-ын багцаас 10,543.7 сая төгрөгийн төсөвтэй, гүйцэтгэгч “Суурь ХХК”-тай 6,800.0 сая төгрөгөөр, 2012-2014 онд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

2012 онд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2,040.0 сая төгрөг авсан, бодит хийгдсэн ажил 680 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Барилга угсралтын ажил 2012 онд эхэлж барилгын суурийн ажил болон баганын арматурчлалын ажил хийгдэн зогсож, 2019 онд газар шороо, цутгамал төмөр бетон бүтээцийн угсралтын ажил хийгдэж түүнээс хойш ажил хийгдээгүй байна.

Тус барилгын ажлын тендер шалгаруулалт, гэрээ байгуулах ажил нь анх БСШУ-ны яаман дээр зохион байгуулагдсан тул орон нутагт ажлын гүйцэтгэл, санхүүжилт, хэрэгжихгүй удааширалтай байгаа шалтгаан түүний шийдвэрлэлтийн явцыг мэдэхэд төвөгтэй албан ёсны мэдээлэл бага байгаа хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулахад хүндрэлтэй байна.

Аудитын явцад тус барилгын хэрэгцээ шаардлагыг судалж үзэхэд тус барилга нь 1984 онд “Кино театр”-ын зориулалтаар баригдан ашиглалтад орж байсан бөгөөд 2015 онд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тус барилга нь **“Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрх зөрчигдөж, соёлын үйл ажиллагааг хэвийн явуулах боломгүй байна”** гэж дүгнэгдсэн байна. /Хавсралт7-9/ /Бүлэг Б.2-оос дэлгэрэнгүй харна уу/

### **Санал 3:**

Иймд тодорхой бус шалтгаанаар дуусаагүй орхигдсон дээрх барилга нь манай аймгийн хувьд нэн тэргүүний шаардлагатай байгаа нь нотлогдож байгаа тул барилгын ажил удааширч байгаа учир шалтгааныг тогтоож асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажлыг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар Соёлын яаманд зөвлөмж хүргүүлэх.



## Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



### ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд танилцаа.

Тухайн тайлангийн төсөлд ямар нэг санал, тайлбаргүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА *Б.Орденэ* Н.ОРДЭНЭ ОЧИР

4822170553

**2020 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙДАЛ**

Д/д	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	2021 оны хөгжлийн төлөвлөгөө	2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2020-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
1	Сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам шугам сүлжээ, барилга байгууламж /Дундговь, Дэлгэрцогт сум/	1,900.0	1,900.0	6.1.1.Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах		6.1.1.Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах
2	Сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Дундговь, Сайхан-Овоо сум/	1,900.0	950.0	6.1.1.Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах		6.1.1.Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах
3	Сургуулийн дотуур байрны барилга /Дундговь, Гурвансайхан сум/	1,040.0	540.0		2.1.2.1 Шаардлагатай сумдад сургууль, дотуур байрны барилгыг барина.	
4	Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум, Говийн-Ирээдүй цоцолбор/	5,496.4	2,748.2	2.3.2.1 Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, сумдад шинээр сургуулийн барилга барих	2.1.2.1 Шаардлагатай сумдад сургууль, дотуур байрны барилгыг барина.	
5	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Дундговь, Сайхан-Овоо сум/	3,096.4	1,548.2		2.1.2.1 Шаардлагатай сумдад сургууль, дотуур байрны барилгыг барина.	
6	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	400.0	200.0			
7	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Өлзийт сум/	300.0	150.0			
8	"Их соёл-Эх үндэс" төсөл, хөтөлбөр /Дундговь/	300.0	300.0	2.3.1.4 СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах		
9	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/	80.0	65.9			
10	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар /Дундговь, Эрдэнэдалай сум/	40.0	32.5			

11	"Төв халх" дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/	10,543.7	1,710.0	2.5.1.1 Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулах	1.1.1.1 Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулна	2.5.1.1 Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулах
12	Соёлын төвийн барилга /Дундговь, Дэлгэрцогт сум/	1,000.0	700.0	2.5.1.4 Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай, сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	1.1.1.4 Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.	
13	Соёлын төвийн барилга, 240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	1,230.0	575.0		1.1.1.4 Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.	
14	Соёлын төвийн барилга, соёлын заал, 400 суудал, номын сан, 45 суудал /Дундговь, Эрдэнэдалай сум/	1,800.0	1,500.0		1.1.1.4 Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.	
15	"Их соёл-Эх үндэс" төсөл, хөтөлбөр /Дундговь/	200.0	200.0			
16	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Сайнцагаан сум/	2,200.0	476.0			
17		1,800.0	294.0	6.1.1.5 Эрдэнэдалай сумын 2 км хатуу хучилттай авто зам,		6.1.1.5 Эрдэнэдалай сумын 2 км хатуу хучилттай авто зам,

	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/			гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах		гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах
18	Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто замын зураг төсөв, 540 км /Дундговь, Сайнцагаан/	2,000.0	2,000.0	3.6.1.2 Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах		
19	Онги голын төмөр бетон гүүр, 54.8 у/м /Дундговь, Сайхан-Овоо сум/	1,528.4	1,007.8			
20	"Шинэ хөдөө" төсөл /Дундговь/	300.0	300.0			
21	Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	439.7	439.7			3.5.1.5 Аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын цахилгааны эх үүсвэр холбох 220/110/35кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг ашиглалтад оруулах
22	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Дундговь, Сайнцагаан сум/	8,752.9	5,000.0	2.3.1.1 Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих.		2.1.3.1.1 Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих.
23	Сум дундын эмнэлгийн барилга /Дундговь, Эрдэнэдалай сум/	2,200.0	56.0			
24	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	40.0	40.0			
25	Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах	50.0	49.9	5.1 Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлэх	6.2.2.1 Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгоно.	5.1.4.1 Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгох

**ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ /ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУГАЦАА/  
СУДАЛГАА №1**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг/	Тухайн онд санхүүжих дүн /сая төг/	ТЕЗ-ийн нэр	Эрх шилжүүлсэн шийдвэр, огноо, дугаар		Үнэлгээний хорооны худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа			
		Эхлэх	Дуусах				ТЕЗ-ийн шийдвэр	ТЕЗ-ийн огноо, дугаар	Үнэлгээний хороо			
									Байгуулахаар төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Эрх шилжсэн хугацаанаас хойш байгуулсан
A	1	2	3	4	5	7	7	8	9	10=9-8	11=7-9	
1	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дундговь, Дэлгэрцогт/	2021	2021	80.0	65.9	Аймгийн Засаг дарга	БСШУ сайдын тушаал А/13	1/18/2021	2/25/2021	3/23/2021	26	64
2	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар/Дундговь, Эрдэнэдалай/	2021	2021	40.0	32.5	Аймгийн Засаг дарга	БСШУ сайдын тушаал А/14	1/18/2021	2/25/2021	4/23/2021	57	95
3	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байгуулах	2021	2021	40.0	40.0	Аймгийн Засаг дарга	БОАЖС-ын тушаал А/34	1/29/2021	3/19/2021	6/3/2021	76	125
4	Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах	2021	2021	50.0	49.9	Аймгийн Засаг дарга	БОАЖС-ын тушаал А/34	1/29/2021	3/19/2021	4/23/2021	35	84
<b>НИЙТ ДҮН</b>				<b>210.0</b>	<b>188.3</b>							

**ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ /ТЕНДЕРИЙН ХУГАЦАА/ СУДАЛГАА №2**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг/	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа								
		Эхлэх	Дуусах		Тендер							Хүчинтэй байх хугацаа	
					Зарлахаар төлөвлөсөн огноо	Зарласан огноо	Хэтэрсэн хоног	Тендер хүлээж авах эцсийн хугацаа	Үнэлгээний хорооны дүгнэлт гарсан огноо	Харьцуулалт 5 хоног, Нээлттэй 30 хоног дээш хоногт хүлээж авах хугацаа	Тендерт зарцуулсан нийт хугацаа, хоног	Тендерийн хүчинтэй байх хугацаа	Тендерийн хүчинтэй байх хугацааг сунгуулсан эсэх /тийм, үгүй/
1	2	3	18	19	20=19-18	21	22	23=21-19	24=22-21	25	26		
1	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дундговь, Дэлгэрцогт/	2021	2021	80.0	3/3/2021	3/30/2021	27	4/12/2021	4/20/2021	13	8	5/12/2021	үгүй
2	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар/Дундговь, Эрдэнэдалай/	2021	2021	40.0	3/11/2021	4/30/2021	50	5/12/2021	5/17/2021	12	5	6/12/2021	үгүй
3	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байгуулах	2021	2021	40.0	3/25/2021	6/28/2021	95	7/6/2021	7/6/2021	8	0	8/6/2021	үгүй
4	Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах	2021	2021	50.0	3/25/2021	5/3/2021	39	6/3/2021	6/8/2021	31	5	7/3/2021	үгүй
<b>НИЙТ ДҮН</b>				<b>210.0</b>									

**ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ / ГЭРЭЭ БАЙГУУЛАХ/ ХУГАЦААНЫ СУДАЛГАА №3**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байриил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг/	ХАА мөрдсөн хугацаа					
		Эхлэх	Дуусах		Гэрээ байгуулах эрх олгох			Гэрээний		
					Төлөвлөсөн огноо	Эрх олгосон огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Байгуулахаар төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног
А		1	2	3	29	30	31=30-29	32	33	34=33-32
1	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дундговь, Дэлгэрцогт/	2021	2021	80.0	3/24/2021	4/28/2021	35	2021/4/28	2021/5/7	9
2	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар/Дундговь, Эрдэнэдалай/	2021	2021	40.0	4/20/2021	5/28/2021	38	2021/5/28	2021/6/10	13
3	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байгуулах	2021	2021	40.0	3/26/2021	7/8/2021	104	2021/7/8	2021/7/27	19
4	Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах	2021	2021	50.0	3/26/2021	6/8/2021	74	2021/6/8	2021/6/22	14
<b>НИЙТ ДҮН</b>				<b>210.0</b>						

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ / ТЕНДЕРИЙН ҮР ДҮН/ СУДАЛГАА №3

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг/	ТЕЗ-ийн нэр	Эрх шилжүүлсэн шийдвэр, огноо, дугаар		ХАА-нд мөрдөгдсөн журам					Шалгарсан гүйцэтгэгчийн нэр	Шалгарсан төсөвт өртгийн дүн	
		Эхлэх	Дуусах			ТЕЗ-ийн шийдвэр	ТЕЗ-ийн огноо, дугаар	Нээлттэй	Тендер шалгаруулалтын онцгой журам			ХАА-г зарласан хэлбэр			
									Хязгаарлагдмал	Харьцуулалт	Шууд гэрээ	Уламжлалт			Цахим
А	1	2	3	5	7	7	8		9	10	11	12	13	37	38
1	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дундговь, Дэлгэрцогт/	2021	2021	80.0	Аймгийн Засаг дарга	БСШУ сайдын тушаал А/13	1/18/2021			тийм			тийм	Ашид бьюлдинг ХХК	65,877,523
2	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар/Дундговь, Эрдэнэдалай/	2021	2021	40.0	Аймгийн Засаг дарга	БСШУ сайдын тушаал А/14	1/18/2021			тийм			тийм	Юу Би Жи ХХК	38,500,744
3	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байгуулах	2021	2021	40.0	Аймгийн Засаг дарга	БОАЖС-ын тушаал А/34	1/29/2021			тийм			тийм	Акиус ХХК	40,000,000
4	Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалах зурвас байгуулах	2021	2021	50.0	Аймгийн Засаг дарга	БОАЖС-ын тушаал А/34	1/29/2021			тийм			тийм	Дундговь-Ус ОНӨААТҮГ	49,900,000
<b>НИЙТ ДҮН</b>				<b>210.0</b>											

НЭМЭЛТ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

/ ГЭРЭЭ СУНГАСАН ХУГАЦААГААР /

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Гэрээний хэрэгжилт				Нэмэлт гэрээ		
			Анх байгуулсан гэрээний дун	Гэрээгээр дуусах хугацаа	Хүлээн авсан хугацаа/комиссын дүгнэлт/	Хугацаандаа хэрэгжсэн эсэх	Нэмэлт гэрээ байгуулсан тоо	Шалтгаан	Нэмэлт гэрээ дуусах хугацаа
1	Цэцэрлэгийн барилгын их засвар/Дундговь, Дэлгэрцогт/	80.0	65.9	5/26/2021	6/4/2021	Тийм			
2	Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар/Дундговь, Эрдэнэдалай сум/	40.0	38.5	8/1/2021	10/20/2021	Тийм			
3	Сургуулийн барилгын их засвар/Дундговь Өлзийт сум/	400.0	377.5	8/20/2021	21/12/2021	Тийм	25/08/2021	Ковид -19 шалтгаалан бараа материалын хомсдол их	9/18/2021
4	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дундговь Өлзийт сум/	300.0	278.9	8/20/2021	6/22/2020			-	
5	Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	40.0	40.0	9/10/2021	9/10/2021	Тийм			
6	Дундговь аймгийн цөлжилт газрын доройтолд өртсөн хамгаалах зурвас байгуулах	50.0	49.9	9/5/2021	9/15/2021	Тийм			
7	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/	2,200.0	2,176.0	7/10/2020	9/23/2021	Үгүй	25/12/2019, 08/10/2020, 08/02/2021	- 1 дэхь нэмэлт гэрээ хугацаа сунгасан / Захиалагчийн дагуу Хүүхдийн ордны зүүн талын замын тохижилтын ажлыг өөрчилсөн/ - 2 нэмэлт гэрээ нь /хийж буй ажилд төсөвт тусгаагүй зайлиггүй хийх шаардлагатай далан засах ажил/ - 3 нэмэлт гэрээ нь ажлын хугацаа сунгасан	7/5/2020, 6/01/2021, 1/31/2022

8	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/ БАГЦ - 1	1,800.0	1,505.4	10/1/2020		Үгүй	-	-	-
	Сумын төвийн хатуу хучилттай авто замын гэрэлтүүлэг, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/ БАГЦ - 2		217.5	9/1/2020		Үгүй	25/08/2021	2020 он ажлыг хийж дууссан боловч. 2022 онд комисс хүлээж авсан	1/31/2022
<b>НИЙТ ДҮН</b>		<b>4,910.0</b>	<b>4,532.1</b>						

“ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖУЖГИЙН ТЕАТРЫН ХУУЧИН БАРИЛГА”-ЫН ЧАНАР ТӨЛӨВ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ №1



ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖУЖГИЙН ТЕАТРТ

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНӨЛТ

Илгээ Сэвдэглээн сум, Дундговь аймаг  
Утас/факс: 70-59-30-28

Бичиг: P.64@korestan.gov.mn, mh@bairilga.gov.mn

ХС/15.06.16 № 13-02-010/63

Барилгын чанар, төлөв байдлын тухай

Сэвдэглээн сумын Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын чанар, төлөв байдлыг тус театрын даргын 2015 оны 5-р сарын 26-ны өдрийн 88 тоот албан бичгээр ирүүлсэн хувиартай дагуу 2015 оны 6-р сарын 15-нд аймгийн МХГ-ын Барилга төхөөрөмжийн хяналтын улсын байцаагч ЭЦЦэрэннадмид, театрын дарга Д.Доржсүрэн, менежер Б.Амгалан бид газар дээр нь үзэж шалтгаалаа.

Уг сарын төвийн барилгын 1984 онд шугамар суурь, төрсөн хана, төмөр бетон хөрш, гунгалт, хар цаасан дэвсгэртэй модон хаалга дэнхтэй барьж ашиглалтанд оруулсан.

Одоогоор барилгын чанар муудаж барилгын суурь баруун болон урд хэсгээрээ суулт өгч цуурсан, гадна хана зарим хэсгээр цуурсан, онгалгаа шаазар нь хагарсан, дотор сэлгэл элэгдсэн, барилгын гадна хана дулаан алдалт ихтэйгээс барилгын зарим хана гээж, хана шаазны булан уулзаараар цэнгдэг. Барилгын хуучин модон дэнх нь зөв зэвсгэр ихтэйгээс дулаан алдалт ихтэй, дээррийн бий битүү байдал алдагдаж барооны ус гомддог, барооны ус гомддогос дотор хана, таазны замаас эмальс норж шарласан хуурч унасан. Мөн дээрээс нөнгөрч орсон барооны уснаас тайзны хэсгийн гэрэлтүүлэг, цахилгааны монтажанд богино хөлбөө үүсч ажилчид болон урал бүтээлчид тогтоод, дохиолох тал гарах магадлал ондөр болсон байна.

Уг барилга нь энх кино театрын барилгын зориулалтаар ашиглалтанд орсон бөгөөд дуулалт жүжгийн театрын зориулалтаар үйл ажиллагаа явуулахад ихэрхэн хүндрэлтэй байгаа бөгөөд осолны барилгын зайн хэмжээний тухай норм норматив стандартын шаардлага хангах үй байна.

Тус барилгын № 5.2 хэсгийн барилга баргууламжийн ашиглалтыг шалгах хяналтын хуудас" аар шалгахад, Их эрдэлтэй гарсан.

Эдгээр байдал нь хүний амьдралд аюулгүй орчинд ажиллах эрх зөрчилдөж, осолны үйл ажиллагааг хэвийн болгохгүй болсон байна.

ДҮГНЭЛТ болгох нь:

Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгад илэрсэн зөрчил нь барилгын бат бэхийг бууруулж, барилгын тухай хуулийн 9.1.1 хүйг ажилдаж, амьдрах таалах.

0800185

Хавсралт 8

**“ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖУЖГИЙН ТЕАТРЫН ХУУЧИН  
БАРИЛГА”-ЫН ЧАНАР ТӨЛӨВ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ №1-ИЙН ҮРГЭЛЖЛЭЛ**

нөхцөл бүрдүүлсэн, түүний зорилт мандэд өвсгөж мөнгөөр, аюулаар байдлыг хангасан  
байсан гэсэн барилга байгууламжид төвлөх шаардлага ашиглалтын хэвийн нөхцөл  
найвартай ажиллагааг хангахгүй байна

ДУГНЭЛТ БАРИЛГА  
БАРИЛГЫН ТӨЛӨӨ АШИГЛАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧИД ХАНАЛТЫН  
ЭНЦӨРӨННАДМИД



**“ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖҮЖГИЙН ТЕАТРЫН ХУУЧИН  
БАРИЛГА”-ЫН ЧАНАР ТӨЛӨВ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ №2**



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

2015 оны 07 дугаар сарын 07

№ 5/18

Мөнгөлцөө

**ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖҮЖГИЙН ТЕАТРЫН  
ДАРГА Д.ДОРЖСҮРЭН ТАНАА**

Тус аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театр хүсэлт гаргасны дагуу 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, онцгой байдлын ахлах дэслэгч Э.Мөнхбаатар би холбогдох дарга, няравын хамт гамшиг орол, гал түймрээс урьдчилан сэргийлсэн байдалд хяналт шалгалтын дүгнэлт болгох нь.

**Нэг. Төв халхын дуулалт жүжгийн театрын  
товч танилцуулга**

Уг барилга нь тоосгон хийц бүтээцтэй, цементэн цутгаалал шалтайгаар 1384 онд 1203 метр. квадрат талбайтай баригдаж ангилагтанд өссөн.

Хөёр. Төв халхын дуулалт жүжгийн театрт хяналт шалгалт хийсэн талаар

Хяналт шалгалтаар уг барилын тайз болон үзэгчидийн дөвөрийн хэсэгт ус нэвтрэн орж гэрэлтүүлэг болон цахилгааны дотоо монтажинд богино холболт үүсэн гал түнмэр гарах шалтгаан нөхцөл бүрдээд байгаа тул үзвэр үйлчилгээ явуулах боломжгүй болсон байна.

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ  
ОНЦГОЙ БАЙДЛЫН АХЛАХ ДЭСЛЭГЧ Э.МӨНХБААТАР

*Зураг 4*

*COVID-19 цар тахал, бараа материалын үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан 2021 онд ажил хийгдээгүй барилгууд;*

- 1. “Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга” –ын ажил /1,228.3 сая/*



*Зураг 5*

- 2. “Говь-Угтаал сумын спорт заалны барилга”-ын ажил /853.2 сая /*



Дуусаагүй орхигдсон барилга:

Зураг 6

*“Дундговь аймгийн 800 суудалтай Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга”-ын ажил*



Зураг 7

*“Цагаандэлгэр сумын халуун ус ахуй үйлчилгээний барилга”-ын ажил; /237.3 сая/*



Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг  
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39  
E-mail: [dundgovi@audit.gov.mn](mailto:dundgovi@audit.gov.mn) 